

# **ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО**

Залуучуудын оролцооны байгууллагын нийтлэг зөрчлийг шийдэх

Бэлтгэсэн: Мягмарсүх Н.

Монгол Улсын Их Сургууль

Утас: 80933993

E – mail: [myagmarsukhna@gmail.com](mailto:myagmarsukhna@gmail.com)

## Залуучуудын оролцоо

**Дэд сэдэв: Залуучуудын оролцооны байгууллагын нийтлэг зөрчлийг шийдэх**

Нармандахын Мягмарсүх

Монгол Улсын Их Сургууль – Шинжлэх Ухааны Сургууль

Цахим шуудан: [myagmarsukhna@gmail.com](mailto:myagmarsukhna@gmail.com)

### Хураангуй

**Түлхүүр үг:** Залуучууд, оролцоо, зорилго, ашиг сонирхол, хувь хүн

### Оршил

21 – р зууны даяаршил эрчээ авсан капиталист нийгэмд хувь хүний хөгжил, авьяас чадвар нь тэднийг тухайн ажиллаж буй албан газар, хамт олны дунд өөрийн байр суурийг олж, хүлээн зөвшөөрөгдөх үйл явцад голлох үүргийг гүйцэтгэх болсон. \ Бизнесийн байгууллагуудын хувьд ажлын байранд тавигдах шаардлага нь хандлага, харилцаа, ур чадвар, туршлага, мэдлэгээр тодорхойлогдож байгаа<sup>1</sup> \ Тэгвэл нийгэмд тодорхой мастер статустай болоход тань нөлөөлж буй тэрхүү чадвар, авьяасыг нээн илрүүлэхэд онц ач холбогдолтой зүйл бол **“Оролцоо”** юм.

Оролдлого сайт оройд нь<sup>2</sup> . Ямар ч зүйлийг хүн өөрийн оролдлого оролцооны тусламжтайгаар суралцдаг. Энэхүү зарчмын дагуу биднийг оролцоод хөгжихийг шаарддаг өрсөлдөөнт нийгэмд тавигддаг бас нэгэн шалгуур бол багаар ажиллах чадвар. Оролцоо нь өөрөө багаар ажиллах гэгч ойлголттой салшгүй холбоотой зүйл юм. Залуусын байгууллагуудын нийтлэг үзэл санаа нь нийгэмд эерэг хандлагыг төрүүлэхэд оршдог тэгвэл дотоод уур амьсгал, гишүүдийнхээ асуудлыг шийдэж чадаагүй байгууллага нийгэмд нөлөөлж чадах уу?

### Сэдвийн үндэслэл:

Миний бие **“Залуучуудын нийгмийн оролцоон дахь хувийн ашиг сонирхол”** сэдвийн дагуу **Монгол Улсын Их Сургууль** – ийн бакалаврын 1 – 4 дүгээр

---

<sup>1</sup> Хүний нөөцийн менежмент

<sup>2</sup> Монгол ардын зүйр цэцэн үг

түвшинд суралцаж буй 16 – 24 насны 140 оюутны дунд санал асуулга \online хэлбэрээр\ явуулсан [\Хавсралт 1\](#). Судалгааны үр дүнгээс харахад оюутнуудын ихэнх хувь нь оюутны зөвлөл аль эсвэл клуб, дугуйланд элсэхдээ өөрсдийн хувийн ашиг сонирхлын дагуу элссэн бөгөөд тэрхүү хувийн сонирхлоо баг хамт олны дунд хэрэгжүүлэх сонирхолтой байдаг ба тухайн үйл ажиллагаанд нь гар бие оролцож буй сонирхлын бүлгээсээ өөрт эдийн болон эдийн бус ашиг хонжоог ямар нэгэн байдлаар хүсэмжилдэг гэсэн дүгнэлт гарсан.

Уг дүгнэлтээс харгалзан энэхүү илтгэлийг бэлдсэн болно.

**Зорилго:** Залуучуудын нийгмийн оролцоон дахь хувийн ашиг сонирхлыг нийтийн ашиг сонирхолтой нийцүүлэн үр дүнтэй ажиллах шинэ зарчмыг дэвшүүлэх.

**Зорилт:**

- Залуучуудын нийгмийн ажилд оролцож буй нийтлэг зорилгыг судалж мэдэх
- Нийгмийн ажилд оролцоход нь саад тотгор болж буй зүйлийг таниж мэдэх
- Оролцоонд тулгамдаж буй асуудлыг шийдэж, багийн хамтаар хийж буй үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох санал дэвшүүлэх

**Залуучуудын оролцоо**


Хувь хүний ашиг сонирхол нь нэг талаараа залуусын оролцоог илүү нэмэгдүүлэх шинжтэй байдаг ч хувь хүний өөрийн сонирхол нийтийн зорилго, зорилттой нийцэхгүй байх тохиолдол байдаг. Ингэснээр баг хамт олны дунд таагүй уур амьсгал бүрдэх хандлага гардаг ба тэрхүү нөхцөлд үүссэн таагүй орчноос хамааран сонирхлын бүлгийн ажлын бүтээмж мууддаг. Цаашлаад тухайн бүлгийн гишүүд хоорондоо ам муруйх, нэгэндээ дургүй болох, тарах үр дүнд хүрдэг. Судалгааны үр дүнгээс харахад ихэнх залуус сайн дурын байгууллагын үйл ажиллагаанд оролцохдоо дараах нийтлэг ашиг сонирхлын дагуу элсдэг.

- **Тэтгэлэг авахдаа нийгмийн идэвх хэсэгт бөглөх тодорхойлолт хийлгэх зорилгоор**
- **Олон нийтийн дунд нэр хүнд олж авч хувийн кареерийг нэмэгдүүлэх**

- **Ямар нэг хичээлийн багш шаардсаны дагуу нэмэлт оноо авах гэж**
- **Тухайн ажлыг хийснийхээ төлөө тодорхой хэмжээний хөлс авах гэж**


Энэ мэт хувийн ашиг сонирхол нь сайн дурын байгууллагын гишүүдийн дунд нэлээдгүй түгээмэл байдаг. Харин энэхүү хүсэл зорилготой нь байгууллагын зорилго зорилт нийцээгүй тохиолдолд үл ойлголцол гардаг.

Судалгааны үндсэн дээр би туршлага судлах зорилгоор **Indiana University Blooming** – ийн оюутны холбооны тэргүүн Bryce Bennet тэй цаг товлож Skype – аар ярилцсан. Тэрхүү ярилцлагынхаа хүрээнд би тус их сургуулийн оюутны конгрессийн ажиллах зарчмаас туршлага судалсан. Яагаад заавал Индианагийн Их Сургуулийг сонгосон бэ гэвэл тус сургуулийн оюутны конгрессийн үйл ажиллагаа нь муждаа тэргүүлэх үр дүнг өнгөрсөн 2016 онд үзүүлээд байсан юм. Тэдний багаар ажиллах систем нь их энгийн. [\Зураг 1\](#)



Уг энгийн системийн дагуу ажилладаг бөгөөл гарсан асуудлыг тэр дор нь шийдэх зарчмаар тасралтгүй явагддаг процессийг тусгаж өгсөн.

Өнөөгийн ихэнх оролцооны байгууллагууд нь хувь хүн буюу гишүүдийнхээ хэрэгцээ шаардлагыг төдийлөн авч үздэггүй, багаар ажиллах зарчим, систем нь ч ойлгомжгүй байдаг. Үүнийг шийдэх Икигай зарчим [\Зураг 2\](#) :



Энэхүү зургаас харахад хувь хүний хэрэгцээ болон нийтийн хэрэгцээнд адил төстэй тал байдаг бөгөөд тэрхүү талуудын огтлолцол дээрээс үр дүнтэй ажиллах, оролцоод хөгжих боломж гарч ирж байгаа юм.

### Дүгнэлт

Оролцооны байгууллагуудын дотоод зөрчлийн нийтлэг хэлбэр нь гишүүдийн хувийн эрх ашгаа хэрэгжүүлэх гэсэн хүсэл болоод байгууллагын зорилго зорилт нь тэдний сонирхолтой уялдаа холбоо муутайгаас болон үүсэх хандлагатай байдаг. Хамт олны доторх хувь хүний ашиг сонирхол буюу хэрэгцээг оролцооны байгууллага гэлтгүй бизнесийн байгууллагууд ч гэсэн бодлого судалгаандаа тусгаж өгөх хэрэгтэй бөгөөд ингэснээр байгууллагын дотоод зөрчил багасаж , цагийг илүү үр бүтээлтэй өнгөрөөж, үр дүнтэй ажиллахад дөхөм болж өгөх юм.

Ном зүй

- [1]. Бизнесийн статистик Л. Эрдэнэсүвд Улаанбаатар 2010 он
- [2]. Бүх талын боловсрол олгох сургалтын таван талт зарчим Вонь Дун Ёнь 2005 он
- [3]. Bushido The Way of the Samurai Tsunetomo Yamamoto
- [4]. Human Resource Management Christopher Cashelcordo, Grace Smith
- [5]. Indiana University Bloomington Student Congress Bryce Bennet